



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.07.03 № 03/11425.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
С.ТӨГСДЭЛГЭР ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай


Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг “эрүүл мэндийн салбарт гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах, дүн шинжилгээ хийж, авлигын эрсдэлийг тогтоох, түүнд тулгуурлан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах” зорилгоор Эрүүл мэндийн яам, холбогдох төслийн нэгжүүдэд ажиллалаа.

Ийнхүү ажиллах явцад тогтоогдсон нөхцөл, байдалтай холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай Зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжид дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Хавсралт 8 хуудастай.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг “Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөртэй танилцах удирдамж”-ийн дагуу Эрүүл мэндийн яам, холбогдох төслийн нэгжүүдэд ажилласантай холбогдуулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

**Зөвлөмж 1.** Эрүүл мэндийн салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийн явцын хяналтыг сайжруулах арга хэмжээ авах;

**Зөвлөмж 2.** Төсөл, хөтөлбөр (төсөв)-ийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахаас урьдчилан сэргийлэх, үр ашиггүй, тэвчиж болох зардлыг гаргахгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх;

**Зөвлөмж 3.** Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн зохицуулагч, ажилтны сул орон тоог ил тод, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох, сонгон шалгаруулалтад холбоотой баримт материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;

**Зөвлөмж 4.** Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, Төслийн Удирдах хороо, төслийн Захирал, Зохицуулагчаас ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол түүнийг арилгах, үүсч болзошгүй тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч ажиллах, хяналтыг сайжруулах;

**Зөвлөмж 5.** Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө(төсөв)-с санхүүжилт авч, төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа Төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтнуудын жагсаалтыг гаргаж Авлигатай тэмцэх газарт ирүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг авах, тэднийг энэ талаарх сургалт, мэдээллээр хангах;

**Зөвлөмж 6.** Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн салбар хүлээн авагч байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, чадавхад явцын үнэлгээ хийх, заавар зөвлөмж өгөх, холбогдох арга хэмжээ авах, дараагийн салбар хүлээн авагчийг сонгон шалгаруулахдаа сонирхлын зөрчил үүсгэхгүйц нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх;

**Зөвлөмж 7.** Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хуульд заасан хариуцлага ногдуулдаг байх;

**Зөвлөмж 8.** Төрийн тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа ТББ-аас явуулж буй худалдан авах ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, төслийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

**Зөвлөмж 9.** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох мэдээ, мэдээллийг хуульд заасан хэлбэрээр олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх, Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн Удирдлагын мэдээллийн систем” буюу **odamis.mof.gov.mn** системийн хөтлөлтийг сайжруулах;

**Зөвлөмж 10.** Төсөл хэрэгжиж дууссаны дараа төслийн үр нөлөөний үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, холбогдох журмын дагуу хараат бус мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн үр нөлөөний үнэлгээний тайланг “Удирдлагын мэдээллийн систем(odamis.mof.gov.mn)”-д оруулж хэвших.

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**